



“ЦЭСБ-АУДИТ” ХХК

Нэгдсэн бодох бүртгэл, хяналтын
и гэрээлэгдсэн үйлчилгээний хангамж

4256743, Дархан Уул аймаг, Дархан сум, 10-р баг,
5-р хороо “ПХА” ХХК-ий 2 давхар 65 тоот
Утас/факс: 95112680, 83275858

2024.08.20 № 2/003
танай _____-ны № _____

“ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ”
ХХК-ИЙН УДИРДЛАГА-Д

Хараат бус аудиторын дүгнэлт

Бид энэхүү “Дархан зочид буудал” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тайлан тэнцэл, тухайн өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр тус компанийн санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн, зөв бодитой үзүүлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудыг дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд багтсан хэдий ч санхүүгийн тайлан ба аудиторын тайланд багтаагүй мэдээллээс бүрдэнэ. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй тул бид бусад мэдээлэлд баталгаажуулалт гаргахгүй. Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай эсвэл аудитын явцад бидний олж авсан ойлголттой нийцэж байгаа эсэх эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болзошгүй эсэхийг тодорхойлох явдал юм.

Дээр дурьдсан горимуудыг гүйцэтгэх явцад энэхүү бусад мэдээлэлтэй холбоотой материаллаг буруу илэрхийлэл илрүүлсэн бол бид тайлагнах шаардлагатай байдаг. Үүнтэй холбоотой тайлагнах аливаа зүйлс байхгүй.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор компанийн удирдлагын хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, толилуулах нь Компанийн удирдлагын хариуцлага байна. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлага орно.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудиторуудын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гарган, өөр аливаа нэг этгээдэд биш Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох та бүхэнд тайлагнах нь бидний хариуцлага юм. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшиний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Ч.ЦЭРЭННАДМИД